# БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
# ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 15 өдөр Дугаар А/607 Улаанбаатар хот

Гадаад томилолтоор ажиллах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Сангийн сайдын 2011 оны “Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” 188 дугаар тушаал, Барилгын хөгжлийн төвийн 2022 оны А/48 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2.16.1 дахь заалт, мөн захирлын 2019 оны 145 дугаар тушаалаар батлагдсан “Албан томилолтын журам”-ын 3.1, 3.2 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн Захирал Ц.Амарсанааг “Хот төлөвлөлт, барилга байгууламжийн зураг төсөл зохиох, барилга угсралт” ын туршлага судлах сургалт, уулзалтад 2022 оны 11 дүгээр сарын 16-11-ний өдрүүдэд гадаад албан томилолтоор ажиллах тул гадаад албан томилолтоор ажиллах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, албан томилолтын зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Албан томилолтын зардалд шаардагдах 7,048,071.4 /долоон сая дөчин найман мянга далан нэг, дөчин мөнгө/ төгрөгийг гадаад албан томилолтын зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төсөл хөтөлбөрийн хэлтэс /Г.Гантуул/-т зөвшөөрсүгэй.

3. Гадаад албан томилолтоор ажилласан тайланг холбогдох журмын дагуу боловсруулж, танилцуулахыг захирал /Ц.Амарсанаа/-д үүрэг болгосугай.

ХОТ БАЙГУУЛАЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН
ИНСТИТУТИЙН ЭРХЛЭГЧ О.ОДБАЯР

УЛААНБААТАР ХОТ
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨХХҮГ
ТТА7992 ± 5164753